

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХХК

2014 оны 08 сарын 05 өдөр

№ 09

Дундговь аймаг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

Тайлан хүргүүлэх тухай

Манай компани 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүргүүлж байна.

Жич: Тайланг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ЭРДЭНЭЦОГТ

“Мандалговь-Импекс” ХК-ийн 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Нэр: “Мандалговь-Импекс” ХК

Хаяг: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг

Утас: 99155007

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн №: 810001002, регистр №: 2012294

“Мандалговь-Импекс” ХК нь анх 1976 онд ЗХУ-ын туслалцаатай “Барилга угсралтын 6-р трест” нэртэйгээр барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан.

1991 онд хувьчлагдаж “Мандалговь” ХК нэртэй болсон. 1996 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Мандалговь-Импекс” ХК болж, зочид буудал, зоогийн газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

“Мандалговь-Импекс” ХК нь үйлчлүүлэгчдийг стандартад нийцсэн түргэн шуурхай үйлчилгээгээр хангах, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх гол зорилго тавин ажиллахын зэрэгцээ цаашид компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд малын түүхий эдийг бэлтгэх, боловсруулах чиглэлээр судалгаа хийж байна.

Зочид буудлын өрөөнүүд, ресторан, бар, караоке үе шаттайгаар засвар хийн шинээр тохижуулан ажиллаж байна. Зочид буудлын давхарууд, ресторан, бар-караоке, хүлээлгийн танхим, гаднах орчин зэрэг шаардлагатай газруудад хяналтын камер суурилуулсан. Цаашид люкс өрөөний тоог нэмэгдүүлэх, уурын зуухны тогоог солих, бүх өрөөнүүдийн хаалгыг солих, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, татвар, нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2014 оны хагас жилийн байдлаар 13,820,000.00 төгрөгийн орлоготой, борлуулсан бүтээгдхүүний өртөг 7,385,500.00 төгрөг, 14,147,600.00 төгрөгийн зардалтай, 7,713,100.00 төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Цалин хөлсний зардалд 8,280,523.00 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 2,087,400.00 төгрөг, ашиглалтын зардалд 3,313,000.00 төгрөг, татварын байгууллагад 220,000.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Компанийн үндсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй. 2014 оны хагас жилийн байдлаар 7,713,100.00 төгрөгийн алдагдалтай гарсан нь үйлчлүүлэгчдийн тоо багассан, ашиг орлого муу байгаатай холбоотой юм. Монгол улсын хэмжээнд нүүрсний экспортын хэмжээ зогсонги байдалд орсон нь Өмнөговь аймагруу явах хүний урсгал 30-40 хувь хүртэл буурсан нь үйл ажиллагааны орлогод тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.

Компани их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Л.Эрдэнэбүд, Д.Хуушаан, А.Цэцгэдэлгэр, Д.Ганболд, Д.Мөнхсайхан, Ө.Будханд, хараат бус гишүүдээр Н.Энхтуяа, С.Содбаатар, С.Дарханбаатар, төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ө.Будханд, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ц.Сувдаа, гүйцэтгэх захирлаар Ц.Эрдэнэцогт нар ажиллаж байна.

ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан 21,400 ширхэг хувьцаа, ТУЗ-ийн ердийн гишүүн Л.Эрдэнэбүд 11573 ширхэг хувьцаа эзэмшдэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн холбоогүй, нэгдмэл сонирхолгүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нарын 45 хувь нь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан. Сургалтанд хамрагдаагүй гишүүдийг 8 сард сургалтанд хамруулахаар төлөвлөж байна.

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Ц.Эрдэнэцогт	Гүйцэтгэх захирал	дээд	2 жил
2	Д.Хуушаан	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
3	Д.Ганболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	14 жил
4	Д.Мөнхсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	8 жил
5	Л.Эрдэнэбүд	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	18 жил
6	А.Цэцэгдэлгэр	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
7	Ө.Будханд	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	1 жил
8	Н.Энхтуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
9	С.Содбаатар	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
10	С.Дарханбаатар	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
11	Ц.Сувдаа	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд	1 жил

ТУЗ-ийн ердийн гишүүн А.Цэцэгдэлгэр, Д.Мөнхсайхан, Д.Хуушаан, Д.Ганболд нар “Жуулчин говь” ХК, “Монгол савхи” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан “Монгол савхи” ХК-ийн гүйцэтгэх захирлаар, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Мөнхсайхан “Хар хорин интернейшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, ТУЗ-ийн ердийн гишүүн Ө.Будханд “Жуулчин говь” ХК-ийн хараат бус гишүүнээр, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Энхтуяа, С.Дарханбаатар нар “Жуулчин говь” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Сувдаа “Монгол савхи” ХК, “Жуулчин говь” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажилладаг.

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эрхэлдэг ажил / байршил	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Ажнай корпораци	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, “Монгол савхи” ХК-ийн байр	32.96%
2	Д.Хуушаан	“Монгол савхи” ХК-ийн Гүйцэтгэх захирал	29.98%
3	Л.Эрдэнэбүд	хувиараа	16.22%
4	Ч.Цэцэг-Өлзий		5.57%
5	Г.Ганчимэг	“Тавантолгой транс” ХХК-ийн Дэд захирал	5.20%
6	Д.Алтанцэцэг	хувиараа	5.20%

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд 15:00 цагт зарлан хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналын эрхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

- Компанийн 2013 оны үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, Аудитын хорооны тайланг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

2. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Ч.Мөнхтулга, Ч.Тогтохбаяр, А.Цэцэгдэлгэр нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Н.Энхтуяа, Θ.Будханд, С.Дарханбаатар нарыг тус тус сонгов.
3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2014 оны зардлын төсвийг 5 000 000 төгрөгөөр батлав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороодыг байгуулан ажиллуулж байна.